



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЦОЛМОН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Лувсанвандангийн БОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-25-20, 26-26-23, Факс: 26-26-23
E-mail: bold@parliament.mn
http://www.parliament.mn

2016 10. 23 № 12092

танай _____ -ны № _____ -т


Тов тогтоолгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 25 дугаар зүйлийн 25.1-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Санжаасүрэнгийн Зоригийн амь насыг хөнөөсөн хэргийг шийдвэрлэсэн асуудлаар Монгол Улсын Их хуралд 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Олон Улсын Парламентын холбооны удирдах зөвлөлөөс ирүүлсэн шийдвэрийг судалж, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий түр хороог байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсрууллаа.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу тогтоолын төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Тогтоолын төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг хавсаргав /Хавсралт 4 хуудас/.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Л.БОЛД

БАТЛАВ:
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Түр хороо байгуулахад дараах үндэслэл, бодит шаардлага байна гэж үзлээ:

1.Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Олон Улсын парламентийн холбооны Удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн шийдвэрийг судалж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар ахалж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Л.Болд, Д.Ганболд, Л.Мөнхбаатар нар ажиллаж, санал, дүгнэлтээ 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулсан болно.

Ажлын хэсгээс “Олон Улсын парламентын холбооны Удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн шийдвэрийг судалж, холбогдох санал, дүгнэлт гаргах нь хяналтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгийн бүрэн эрхийн хүрээнээс хэтэрсэн асуудал байх тул уг асуудлаар Улсын Их Хурлын түр хороо байгуулан ажиллуулах нь зүйтэй” гэсэн санал гаргасан.

Олон Улсын парламентийн холбооны Удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн шийдвэрт Улсын Их Хурал дэргэдээ парламентын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр тусгайлсан хороо байгуулах нь асуудлыг авч хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөхөд үр дүнтэй болно гэдгийг илэрхийлсэн байдаг.

2.С.Зоригийн амь насыг бүрэлгэсэн хэргийг холбогдох шатны шүүхээс шийдвэрлэсэн хэдий ч хэргийг хэт нэг талыг барьж шийдвэрлэсэн, хэрэгт ач холбогдол бүхий гэрчийг шүүх хуралд оруулаагүй, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх зэргээр хууль бус аргаар хэргийг хүлээлгэсэн байж болзошгүй гэх мэт асуудлууд нь олон нийтэд төдийгүй хохирогчийн ар гэрт хэргийг шударгаар шийдвэрлэсэн гэдэгт эргэлзээ төрүүлээд байгаатай холбоотой иргэдийн дунд хууль хүчний байгууллагад итгэх итгэл сулраад байна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоол нь 2 заалттай бөгөөд нэгд нь түр хорооны үндсэн чиг үүргийг тодорхойлон байгуулах, хоёрт нь тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тогтоох болно.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Олон улсын парламентын холбооны удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн шийдвэрийг судалж, холбогдох санал, дүгнэлт гарган Байнгын хороонд танилцуулах.

Хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно гэсэн Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдаж байгаад болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг бүрдүүлнэ.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, цаашид шинээр боловсруулах нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуультай нийцэж байгаа бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Тогтоол санаачлагч

ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Дээд Шүүхээс С.Зоригийн амь насыг хөнөөсөн хэргийг 2017 онд эцэслэн шийдвэрлэсэн. Гэвч уг шийдвэрийг дагасан маргаан Монгол улсын иргэдийн дунд төдийгүй Олон улсын хүний эрхийн хороо, Олон улсын парламентын холбооны удирдах зөвлөлийн анхаарлын төвд очоод байгаа билээ.

2018 оны гуравдугаар сард Олон улсын парламентын холбооны удирдах зөвлөлөөс Монгол улсын парламентад албан бичиг /шийдвэр/ ирүүлсэн. Уг шийдвэрт "2017 онд шийдэгдсэн Зориг агсны хэргийг шүүн тасалсан ажиллагааг олон улсын хүний эрхийн хэмжүүрийн дагуу зайлшгүй хийгдэх ажиллагаа болон шударга шүүхийн зарчимд нийцүүлж явуулаагүй тул хууль ёсны болон итгэл төрүүлэхүйц болсон гэж үзэхгүй байна,...эрх мэдлийн хуваарилалтын зарчмаа хүндэтгэхийн сацуу уг хэргийг шударга шүүхээр шийдвэрлэсэн бөгөөд цаашид ч шийдвэрлэнэ гэдгийг баталгаажуулах үүднээс Улсын Их Хурал дэргэдээ парламентын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх шинэчилсэн хороог байгуулахыг уриалж байна, мөн Улсын Их Хурлаас авсан арга хэмжээ, гарсан үр дүнг Олон улсын парламентын холбоонд тогтмол мэдээлнэ гэдэгт найдаж байна" хэмээн дурдсан байна.

Хууль зүйн байнгын хорооноос дээрх шийдвэрийг судалж, санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан боловч Олон улсын парламентын холбооны удирдах зөвлөлийн дурдсан "парламентын хянан шалгах чиг үүрэг"-ийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн хязгаарлагдмал нөхцөл байдал үүсээд байгаа тухай санал дүгнэлтийг ажлын хэсгийн зүгээс гаргасан.

Иймд Олон улсын парламентын холбооны удирдах зөвлөлөөс Монгол Улсын парламентад ирүүлсэн шийдвэрийг судалж, санал дүгнэлт боловсруулан чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах чиг үүрэг бүхий түр хороог Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу байгуулан нарийн судлан, үзэх шаардлагатай гэж үзэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулав.

Тогтоол нь түр хорооны үндсэн чиг үүргийг тодорхойлон байгуулах, тогтоолыг дагаж мөрдөх хугацаа гэсэн 2 заалттай болно.

Тогтоолын төсөл санаачлагч

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны...дугаар
сарын...өдөр

Дугаар

Улаанбаатар хот

ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Санжаасүрэнгийн Зоригийн амь насыг хөнөөсөн хэргийг шийдвэрлэсэн асуудлаар Олон улсын парламентын холбооны удирдах зөвлөлөөс ирүүлсэн шийдвэрийг судалж, холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий түр хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- | | |
|-------------------------|------------------------|
| 1/ <i>Д. Болд</i> | Улсын Их Хурлын гишүүн |
| 2/ <i>Ш. БатЗанган</i> | Улсын Их Хурлын гишүүн |
| 3/ <i>Д. Санжмиегов</i> | Улсын Их Хурлын гишүүн |
| 4/ <i>Ц. Нямдорж</i> | Улсын Их Хурлын гишүүн |
| 5/ <i>А. Сүхбат</i> | Улсын Их Хурлын гишүүн |
| 6/ <i>Д. Оюуч-Эрэнц</i> | Улсын Их Хурлын гишүүн |
| 7/ | Улсын Их Хурлын гишүүн |

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

